

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ
ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 09 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 08 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Хууль санаачлагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр баталдаг эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт болон хөрөнгийн зардлын хэмжээг нэмэх, мөн эрдэс баялгийн салбарын орлогын хэт өсөлтөөс хамааралгүйгээр эрдэс баялгийн бус салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөс хамаарч Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон төсвийн тусгай шаардлагад өөрчлөлт оруулах зэрэг зохицуулалтыг тусган хуулийн төслийг боловсруулсан байна. Хуулийн төсөл батлагдсанаар байгалийн баялгаас хамааралтай нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийг хязгаарлах, төсвийн нийт зарлага, санхүүжилтийн эх үүсвэр, төсвийн тэнцлийг бодитой тодорхойлох, төсвийн сахилга бат, ил тод байдал, нэгдмэл цогц байдлыг сайжруулах боломж бүрдэхээр байна.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц төрийн албан хаагчдын цалин, ахмадын тэтгэвэр нэмэгдэх нөхцөл үүссэнтэй холбогдуулан уг төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаагаа илэрхийлж, Засгийн газар нь инфляцад үзүүлэх нөлөөллийн аргачлал, үндэслэл болон хувилбарт тооцооллыг хийн Монголбанкнаас санал авч, хэлэлцсэн эсэх, Монгол Улсын төсөвт тооцоолсон нүүрсний үнэ, эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт болон төсвийн урсгал зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ нь төсвийн зохистой түвшинд байгаа эсэх, мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийг хүчингүй болгож байгаа үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг баталснаас хойш гурваас доошгүй хугацаанд харгалзах тухай жилийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглох

зохицуулалтыг хүчингүй болгохыг дэмжихгүй байгаагаа илэрхийлэн нэгдсэн төсвийн урсгал зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 30 хувиас хэтрүүлэхгүй байх үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хуулийн төсөл нь холбогдох хууль, тогтоомж, мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт болон Олон Улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмжүүдтэй нийцсэн эсэх, гадаад зээлийн ашиглалт, ялангуяа Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц болон газрын тос боловсруулах үйлдвэр барих төслүүдийн зээлийн ашиглалт нь төсвийн төлөвлөлттэй уялдаж байгаа эсэх, төрийн өмчит компаниудаас татварыг урьдчилан төлүүлж байгаа нь төсвийн сахилга батад нийцэж байгаа эсэх, цаашид авах арга хэмжээ, зохицуулалтын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хороодын хуралдаанд оролцсон гишүүдийн 56.7 хувь буюу олонх Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Н.НАРАНБААТАР

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Б.ЗАЯАБАЛ